

МОНГОЛЧУУДЫН ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ ТАЛААРХ ОЙЛГОЛТ, ХАНДАХ ХАНДЛАГА

Ц.ЦЭЦЭГЖАРГАЛ, М.ЭРДЭНЭЧИМЭГ
МУИС, Антропологи-Археологийн тэнхим

Хүн төрөлхтний орон гэр, соёл иргэншлийн өлгий болсон дэлхий ертөнц, байгаль орчноо танин мэдэж түүний нөөц баялгийг үйлдвэрлэл, амьдрал ахуйдаа зохистой ашиглахын зэрэгцээ нөхөн сэргээх, хайрлан хамгаалах нь дэлхийн улс түмнүүдийн тулгамдсан асуудлын нэг болж байна.

Эртнээс нааш Монгол нутагт оршин амьдарч байсан овог аймгуудаас эхлээд өнөө үеийн монгол угсаатан уул ус, газар дэлхий, ан амьтнаа тахин шүтэж байгалийн өвөрмөц онцлогтоо тохируулан аж ахуйгаа эрхэлж ирсэний зэрэгцээ байгаль орчноо хайрлан хамгаалж, зохистой харьцаж ирсэн баялаг өв уламжлалтай ард түмэн билээ. Монгол орны байгаль, хүрээлэн буй орчин олон зуун жилийн турш хадгалагдаж бидний үед унаган төрхөөрөө өвлөгдөн ирсэн нь нүүдлийн соёл иргэншлийн ач холбогдол төдийгүй өвөг дээдсийн маань байгаль орчноо хамгаалах ариун өв, арга ухааны илрэл юм.

Өвөг дээдсийн үеэс уламжлагдаж ирсэн хүрээлэн буй орчны талаарх арвин баялаг мэдлэг, зан заншил өнөө үеийг хүртэл хадгалагдан үлдсэн боловч нийгмийн шинэ тогтолцоо, зах зээлийн харилцаа болон бусад хүчин зүйлээс шалтгаалан өөрчлөгдөж хүрээлэн байгаа орчноо хамгаалж ирсэн уламжлал зан заншил, мэдлэг ухааны өв алдагдахад хүрч байна. Энэхүү өгүүлэлдээ монголчуудын хүрээлэн буй орчны талаарх ойлголт, түүний өөрчлөлт болон хүрээлэн буй орчинд хандах хандлагын талаар тусгахыг зорьсон юм.

Манай орны олон эрдэмтэд хүрээлэн буй орчин, байгаль экологийн асуудалд анхаарлаа хандуулан хууль, эрх зүйн болон түүх, соёл, угсаатны зүйн чиглэлээр судалгаа хийж байна.

Доктор Т. Сэнгэдорж монгол улсын хууль, эрх зүй дэх экологи, байгаль орчныг хамгаалах уламжлал шинэчлэлийн асуудалд анхаарлаа хандуулан судалгаа хийж “Экологийн эрх зүйн уламжлал шинэчлэл” гэсэн нэгэн сэдэвт бүтээл хэвлүүлсэн байна. Энэхүү бүтээлдээ байгаль хамгаалах хууль, хүрээлэн буй орчин хамгаалах нь төрийн үүрэг, байгаль орчин хуулийн түүх, хууль зөрчихөд хүлээлгэх хариуцлагыг нэмэгдүүлэх, өнөөгийн экологийн эрх зүйн хөгжил, экологийн харилцаа зэрэг нилээд өргөн хүрээтэй асуудлыг авч үзжээ.

Х.Пэрлээгийн хэвлүүлсэн “Монголчууд байгаль хамгаалах заншилтай” гэсэн өгүүлэлд Монголчуудын газар нутгийг дархлан хамгаалж ирсэн уламжлалын асуудлыг хөндөхийн зэрэгцээ “Их засаг” хууль болон XVI-XVII зууны үеийн монголын хууль цаазын бичигт амьтан, ус, ой модыг хэрхэн хамгаалах талаар зааж байсныг цухас дурдсан байна.

Хууль зүйн ухааны доктор О. Амархүүгийн бичсэн “Байгаль орчныг хамгаалах монгол зан заншил хууль цааз” гэсэн бүтээлд : Монголчуудын хүрээлэн буй орчны талаарх уламжлалт мэдлэгийг үндсэн агуулга, зарчмаар нь:

1. **Энэрэл хүндэтгэлийн уламжлал:** (газар нутаг, уул, ус, ой мод, ан амьтан ургамлыг хайрлан хамгаалахад чиглэгдсэн уламжлал)
2. **Сургаал номлолын уламжлал:** (байгалийн зүй тогтлыг танин мэдэх, байгалийг хайрлан хүндэлж хориглосон зүйлийг дагаж мөрдвөл сайн, зөрчвөл муу болно гэдгийг багтаасан уламжлал)

3. **Сүсэг бишрэлийн уламжлал:** (хангай дэлхий, уул ус, ой хөвч, араатан жигүүртэн, бүгд цаанаа эзэнтэй ба тэр бүхэнд бүдүүлэг үг хэллэг, үйл ажиллагаагаар хандвал лус савдаг хилэгнэх бөгөөд хүмүүс газар нутаг, уул усандаа аз хийморь, буян заяагаа даатгаж, байнга сүсэглэн залбирч эрүүл энх, элбэг хангалуун амьдрал, сайн сайхан бүхнийг хүсэн залбирал үйлддэг уламжлал)
4. **Ажиглалт танин мэдэхүйн уламжлал:** (байгаль цаг уурын онцлог, элдэв үзэгдэл өөрчлөлтийг амьдралын туршилгаараа танин мэдэж үйл ажиллагаандаа хэрхэн хэрэглэж ирсэн уламжлал)
5. **Хорио цээрлэлийн уламжлал:** (байгалиа хамгаалах хүндэтгэл, ёс журмыг сахих, зан үйлийг хэвшүүлэх, байгаль дэлхийд харьцаж хандахдаа ямар үйлийг тэвчин өнгөрөөхийг үр хойч үедээ уламжлуулан ойлгуулж ирсэн уламжлал) хэмээн ангилж үзсэн. (О.Амархүү.2000)

Мөн энэхүү уламжлал нь монгол төрийн хуулинд хэрхэн хуульчлагдаж уламжлагдан баяжиж ирсэн түүхийг нэгтгэн дүгнэжээ. Энэхүү бүтээл нь байгаль орчны хуулийг монгол зан заншлын хэм хэмжээтэй харьцуулан үзсэнээрээ онцлог юм.

Б. Дашзэвэг “Байгалиа хамгаалж ирсэн Монголчуудын хууль цаазын эртний уламжлал “ нэгэн сэдэвт бүтээлдээ монголчуудын байгаль хамгаалж ирсэн хууль цаазын уламжлалыг түүхэн цаг үе, төрийн үүрэгтэй холбон авч үзэж энэ уламжлал нь хэрхэн уламжлагдан ирсэн талаар тодорхой тусгажээ. О. Шагдарсүрэн “Экологийн танин мэдэхүйн үндэс” бүтээлдээ экологийн шинжлэх ухааны судлах зүйл, ач холбогдол, экологийн хүчин зүйл зэргийг шинжлэх ухааны үүднээс өгүүлсэн бол Т. Сэнгэдорж “Экологийн эрх зүй “номондоо Монгол орны экологийн бүтцийг тодорхойлон энэ ойлголтын ач холбогдлыг авч үзсэн байдаг.

Монголын уламжлалт соёлд хүрээлэн буй орчин нөлөөлсөн нь: Нүүдэлчин монголчууд эрт үеэс өөрийн үндэсний өвөрмөц соёлыг бий болгон хойч үедээ уламжлуулж ирсэн ард түмэн билээ. Бидний өвөг дээдэс эрт үеэс байгалийн бэлчээрт түшиглэсэн нүүдлийн мал аж ахуй эрхэлж ирсэн бөгөөд мал маллах, өсгөх ур ухааны зэрэгцээ нүүдлийн амьдралд зохицсон өвөрмөц орон сууц, тоонот гэр, хувцас хунар, мал аж ахуйн тоног хэрэгсэл зэрэг ахуйн хэрэгцээний эдлэлийг бүтээж бий болгожээ.

Монголын нүүдэлчид Төв Азийн тэгш өндөрлөгийн онгон байгаль, эх газрын эрс тэс уур амьсгалын өвөрмөц хүчин зүйлс, мал амьтан, өвс ургамлын онцлог зэрэг хүрээлэн байгаа орчинтойгоо харьцаж, мэдрэх онцгой мэдрэмжтэй ард түмэн билээ. Оросын нэрт эрдэмтэн Л.П.Гумилев монголчуудыг “Бусад үндэстнүүдээс илүү ухаалаг эрч хүчтэй хүмүүс төрөх байгаль цаг уур, газар зүйн буюу экологийн нөхцлөөр хүрээлэгдсэн байдаг” гэжээ. Нүүдэлчид байгалийн элдэв үзэгдэл бэрхшээлтэй байнга тулгарч хөдөө хөрч, гадаа гандаж явдаг тул байшинд сууж нар салхи бараг үздэггүй суугуул иргэдтэй жишихэд байгаль дэлхийгээс авах эрч хүч илүү их байж болох юм(24).

Монгол хүний зан төлөв нь эрхэлж буй мал аж ахуйтай нь холбоотой бүрэлддэг гэж судлаачид үздэг. Америкийн эрдэмтэн монгол судлаач А.Кампи “Монгол хүний даруу зан чанарыг идэвхгүй хэмээн үзэж огт болохгүй. Үнэндээ монголчууд сэтгэлийн асар их тэнхээтэй эргэцүүлж ухаарах их чадвартай, дотроо бодолтой улсууд бөгөөд Азийн бусад орны ард түмнээс эрс ялгаатай. Тэд их цайлган сэтгэлтэй учраас гадны хүнд бүдүүлэг мэт харагдавч яг дунд нь амьдарсан нэгэнд сайтар ойлгогддог юм” гэжээ. (М.Төмөржав.1992)

Монголчуудын сэтгэлгээ нь байгаль хүн хоёрын харилцаан дээр суурилж бий болох бөгөөд монгол мэдрэмж, монгол ухаанаар илэрхийллээ олдог байна. Малчид мал сүргийнхээ дэргэд бүхэл өдрийг өнгөрөөж байгалийн элдэв үзэгдэлтэй байнга тулгарах явцад өөрийгөө байгаль орчинтойгоо нягт холбоотойгоо ухаарч хүний бүх үйл ажиллагаа байгалиас хамаарч байгааг мэдэрч байгальтайгаа дасан зохицох, байгалийн үзэгдэлтэй тэмцэх арга ухааныг эрсээр иржээ. Монголын ард түмний сэтгэлгээний гол онцлог бол байгаль нийгмийн аливаа үзэгдлийг олон талаас нь тунгаан учрыг нь олж байж хөдлөх туршлагатай чанар юм.

Нүүдэлчин Монголчуудын дунд эрт үеэс төрөө бэхжүүлэхэд анхаарах, төрөө шүтэн үзэх үзэл хүчтэй дэлгэрчээ. Одоо ч гэсэн цай, сүү өрөм идээнийхээ дээжийг “Төрийн минь сүлд өршөө” хэмээн тэнгэр хангайдаа өргөдөг уламжлал хадгалагдан үүджээ.

Монголчуудын эртнээс нааш хэрэглэж ирсэн үндсэн сууц нь эсгий гэр юм. Энэ нь монгол орны байгаль цаг уурын нөхцөл нүүдлийн мал аж ахуй, нийгмийн хөгжлийн түвшинтэй холбоотойгоор үүсэж түүхэн хөгжлийн явцад улам боловсронгуй болсоор иржээ. Гэр нь ачих, зөөх, барих буулгахад хялбар ширүүн салхинд тогтвортой, хүйтэнд халуун, халуунд сэрүүн, саруул, бөх бат, бэлдэхэд хялбар, нүүдлийн нөхцөлд зохицсон, авсаархан сууц юм. Нөгөө талаар нүүдэлч монголчуудын өвөрмөц онцгой бүтээлийн нэг болдог бөгөөд бидний өвөг дээдэс байгаль ертөнцийн тухай мэдлэг ухаанаа ашиглан гэр хэмээх сууцыг бий болгожээ. Малын аясыг дагасан хөдөлгөөнт гэр, бэлчээрийн мал хоёрын үр дүнд байгалийн унаган төрх хадагалагдан үлдсэн байна.

Мөн монголчуудын өмсөж эдэлж ирсэн хувцас нь амьдралын хэв маяг, улирлын байдалд зохицсон, морь унаж, ан хийхэд тохиромжтой, салхи шуурганаас хамгаалсан урт хормойтой, урт ханцуйтай байжээ. Гутал нь эртнээс нааш газар нутаг, ястан угсаатны хувьд өвөрмөц өөр өөр хэв загвартай байсан ба “дөрвөд тосон”, “буриад бойтог”, “торгууд тоохуу” гэх мэт олон төрлүүдтэй. Монголчууд дээр үеэс бүсээ эрх мэдэл төрийн бэлгэдэл гэж хүндэлж дээдэлж ирсэн уламжлалтай бөгөөд бүс буюу саадаг хоромсого, мөн хутга хэтийг уяж бүслэх нь эр хүн оюун ухаан хурц зориг хүч төгс байхыг бэлгэддэг хэмээн ойлгохоос гадна жавар салхи, дээлийн энгэр заамаар орохоос хамгаалах, ойрын хэрэгцээний зүйлсийг өвөрлөх хавчуулахад ихээхэн үүрэгтэй байдаг.

Монголын нүүдэлчдийн амьдралын хэв маяг соёлд хоол ундаа хэрэглэх дүрэм журам онцгой байр суурь эзэлдэг байв. Нүүдэлчдийн хоол хүнс нь цаг улиралын эрс тэс байдал, малчид мал сүргээ хариулан өдөржин шөнөжин явахад өл хоол болох шимт чанарыг агуулсан байдаг.

Монголын байгаль газар зүйн байдал, гадаад далайгаас алслагдсан, эргэн тойрон уул усаар хүрээлэгдсэн зэрэг нь эх газрын эрс тэс уур амьсгалыг нөхцөлдүүлдэг бөгөөд монголын нүүдэлчин малчид цас зуд, ган гачиг зэрэг цаг агаарын болон байгалийн хатуу ширүүн нөхцөл байдалд мал сүргээ зохицуулан өсгөсөөр ирсэн түүхтэй. Монголчууд хүн – мал – байгаль гэсэн 3 талт харилцаанд мал сүргээ өсгөх арга барилыг эзэмшиж байгаль газар орон, ургамал судлалын талаар арвин мэдлэг хуримтлуулжээ. Олон жилийн турш мал маллах явцдаа арвин их туршлагыг хуримтлуулсаны дээр малчдын орон байр, хөдөлмөрийн хуваарь, хот айлын зохион байгуулалт зэргийг бий болгосон нь монголчуудын нүүдлийн амьдрал ахуйгаа хөтлөх арга ухаан, уламжлалын өвөрмөц онцлогийг илэрхийлдэг бөгөөд нүүдлийн мал аж ахуй нь монгол орон, нүүдэлчдийн өвөрмөц соёл, дүр төрх, зан төлөвийг бүрэлдүүлжээ.

Монголчуудын бэлчээрийн мал аж ахуй, өвсний соргог, усны тунгалаг, уулын нөмөр бараадаж, цаг улирлын аясаар нутаг сольж нүүдэллэн амьдарсаар өвөлжөө,

хаваржаа, зуслан, намаржаа гэсэн нүүдлийн амьдралын нэг бүхэл бүтэн эргэлтийг бий болгосон байна. Монгол малчдын нүүдэл бол тэдний олон үеийн ажиглалт, туршлага дээр үндэслэн мал сүрэгтээ тарга хүч авахуулах, нүүдлийн мал аж ахуй хөтлөх уламжлалт аргуудтай уялддаг. Малчдын нүүдлийн чиглэл нь газар зүйн нөхцөлөөс хамааран харилцан адилгүй байдаг. Тал хээрийн малчдын нүүдэл хангай, тал хээр, говийн бүсийг дамжин тууш чиглэлтэй байдаг бол уулархаг нутгийн малчдын нүүдэл нь уулын өвөрт, нуруунд, уул нуруугаар даван нүүх зэргээр нүүдэллэдэг бөгөөд тухайн орон нутгийн байгаль цаг уурын онцлог, уламжлал зэргээс хамаарч тэмээ, үхэр, адууг ашигладаг. Монгол оронд нүүдлийн хэд хэдэн хэв шинж байна. Үүнд:

- Хангайн хэв шинж
- Хээрийн хэв шинж
- Баруун монголын хэв шинж
- Хангайн өврийн хэв шинж
- Дорнодын хэв шинж
- Говийн хэв шинж зэрэг болно.

Мал сүргийн бэлчээр усыг тохируулан хариулах, шинэ нутаг бэлчээр эзэмших, малыг үржүүлэн арчлах, малд тохирсон өвс ургамлыг танин мэдэх, малын ашиг шимийг боловсруулах, цаг агаарын байдлыг урьдчилан таамаглах, малын өвчинг эмнэх, мал маллагааны арга ухаан, зүй тогтлыг танин мэдэх зэрэг үйл ажиллагааны арвин мэдлэг бий болжээ. Мөн үүнээс гадна газар зүй, цаг уур, ургамалын аймаг, адгуус амьтны талаар өргөн мэдлэгийг хуримтлуулсан нь Монголчуудын оюуны соёлын нэг гол ололт болдог.

Монголын ард түмэн хүрээлэн буй орчныхоо өвөрмөц онцлогт зохицсон өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой соёлыг бий болгон үеэс үед өвлүүлсээр ирсэн нь яндашгүй арвин юм.

Хүрээлэн буй орчинд хандах төрт ёсны уламжлал: Монголчууд төр ёсоо дээдлэн, хууль цаазаа тогтоон бэхжүүлж энэ хүрээндээ байгаль орчныг хайрлан хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар тодорхой үйл ажиллагаа явуулж ирсэн. Монгол төрийн байгаль хамгааллын үндэс Хүннүгийн өмнөх үеэс тавигдсан гэж үзэх үндэстэй юм. (Б. Дашзэвэг 1995) Хүннү гүрний өмнөх үед оршиж байсан Чжоу улсын эзэн Му ван МЭӨ 947-928 оны үед Хүннү нарыг довтлон 4 цагаан чоно, 4 цагаан буга аваад буцаж байсан тухай "Түүхийн дээж бичиг" -т өгүүлсэн байдаг. Энэ нь уг амьтдыг шүтэж байсантай холбоотой. Модунь шаньюй "Газар бол улсын үндэс мөн" хэмээн айлдсан нь монгол төрийн байгаль хамгаалалын бодлогын тулгуур үндэс нь болжээ. Чингисийн үед төрийн их заргач Шихихутаг байгаль орчны талаар зөрчил гаргасан хүнд "... Уул дагасан ус, ус дагасан ургамал, мод, удам дамжсан нутаг бэлчээрийг сүйтгэвээс хүйс тэмтэрнэ хэмээн эзэн Чингис зарлиг буулгасан" гэж сонордуулж байсан зэргээс үзэхэд байгаль хамгаалах хуулийн бодлогыг энгийн хүмүүст ухуулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаа явуулж байсны гэрчилж байна.

Монголын нууц товчоонд овог аймгууд тус бүрдээ нутагтай байсан бөгөөд өөрийн эзэмшил нутагтаа ан гөрөө хийхийг зөвшөөрсөн байдаг. Харин тасыг агнахыг хориглосон. Учир нь тас үхсэн амьтдыг идэж байгалийг цэвэршүүлдэг гэж үзэж байсантай холбоотой бөгөөд тасыг анх дархалсан орон бол Монгол юм. (Б. Дашзэвэг 1995)

Монголд 20 гаруй жил амьдарсан Италийн жуулчин Марко Поло өөрийнхөө тэмдэглэлд "... өртөө замын 2 хажуугаар мод тарьсан нь зунд нар шарахгүй сүүдэртэй, өвөл цас дарчихвал талд зам алдаж төөрөхгүй" гэснээс үзэхэд Монголчууд дээр үед хээр талдаа мод тарьж ургуулдаг байжээ. Өгэдэй хаан хүнгүй

говь цөл газарт худаг малтуулж мал амьтныг устай болгож байсан баримт байдаг. Монгол гүрний үндсэн хуулийн дайтай хууль болох Чингисийн "Их засаг" хуульд :... Өвс ногоо ургасан хойно газар нүхлэх, гал алдаж малын бэлчээр шатаавал хатуу цээрлүүлэх, нар сар ус, газар дэлхийд сүслэн мөргөж байхын хамт айл бүхэн цай хоолныхоо дээжийг газар дэлхийдээ өргөж байх, сүү ундааны зүйлсийг газар асгах, хүн мал амьтны ундаа болох байгалийн усанд хөл гараа дүрэх, биеэ угаахыг цээрлэх, ус авахдаа тусгай хутгуур сав хэрэглэж байх, анхны цас орсон үеэс дараа жилийн ногоо соёолох хүртэл их ав хомрого хийх тухай журам тогтоожээ. "Дөрвөн төрийн арван буянт номын цагаан түүх" -д сүм хийдийн дэргэдүүр бүү авла, тойн хүн санваараасаа бусдыг үйлдэж, амьтны амь хороохыг цээрлэнэ гэж зааж байв.

"Алтан хааны цааз бичигт" хулан, тахийг хамаагүй алваас морь тэргүүтэй малаар, буга согоо, бодон гахай алвал үхэр тэргүүтэй 5 малаар, туулайг зөвшөөрөлгүй алвал 10 туулай тутам 1 хонь ав гэж заажээ. Мөн бэлчээр солих, муу санааны үүднээс түймэр тавихад хариуцлага хүлээлгэх, жижиг загас, элээ, хэрээ, улаан хошуут, шаазгай зэрэг амьтныг алвал цаазгүй гэжээ.

"Монгол- Ойрадын цааз"-д хаад ноёдын ав хомрогоо хийх газрыг тусгайлан тогтоож өгдөг байсан бөгөөд хориотой газарт орох эрхгүй анчин хүн журам зөрчихөд малаар торгож байжээ. Мөн нүүхдээ галаа унтраах, өвс ургамал, ой хамгаалахыг заасан байдаг.

"Халх журам"-д Хан уул, Хөгнө, Тохом, Шивэрт, Онгон, Зоргол, Адаацаг, Улаан нуур зэрэг газрыг онголон дархалж газар эзэмших бэлчээр хамгаалах, ан агнах, хүрээ хийдийн газар хуурай нойтон аль ч модыг огтлохгүй байх, түймэр гарваас зартай заргүй ирж унтраах, эс ирвээс ямбатан сайдыг бод мал, энгийн хүнийг бог малаар торгохыг заажээ.

"Юань улсын судар"-д т байгаль хамгаалах, ан агнах журам тогтоосон бөгөөд тагтаанд хонх зүүж тавих, шувуу могойгоор наадах, үхэр малыг тавьж тариа идүүлж сүйтгэхийг хоригложээ.

Богд хаант Монгол улсын хуулинд Богд хааны зарлигаар Хан ууланд Хайрхан цол өргөмжлөн Богд Хан Хайрхан, Чингэлт хоёр хуулинд жимс түүж зугаацан явахыг хоригложээ. Мөн Дунд, Сэлбэ голоос загас барих, ангир буудах, Сонгино, Баянзүрх уулаас ан хийхийг хориглож Оросуудад шаардах бичиг өгч байсан байна. 1915 онд Нийслэл хүрээний ойр тойрноос шавар шороо авах, нүх ухахыг Богдын зарлигаар хориглосон бөгөөд 1919 онд Туул, Сэлбэ голд модыг тасалбаргүйгээр огтлохыг хоригложээ.

Бидний өвөг дээдэс маань уул ус, газар дэлхий, ан амьтнаа шүтэн байгалийн өвөрмөц онцлогтоо дасан зохицсон амьдралын хэв маяг, соёлын өвийг бий болгосон нь байгаль дэлхийгээ шүтэн бишрэх, эрхэмлэн дээдлэх, хайрлан хамгаалах үзэл төлөвшинг тогтоход нөлөөлжээ. Тэнгэр эцэг, газар эхийг шүтэх, хайрлах үзэл санаа нь бэлгэдэл, зан үйл, зан заншлын хэм хэмжээгээр үеэс үед уламжлагдсаар иржээ. Тэр ч бүү хэл хууль цаазаа тогтоон бэхжүүлж энэ хүрээндээ байгаль орчныг хайрлан хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх талаар тодорхой үйл ажиллагаа явуулж ирсэн төрт ёсны уламжлалыг бий болгон хөгжүүлсээр ирсэн нь монголын эртний хууль цаазуудад байгаль хамгаалалтын заалтууд агуулгаараа улам баяжигдаж ирсэнээс тодорхой харагдаж байна.

СУДАЛГААНЫ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН, АРГА ЗҮЙ

Монголчуудын хүрээлэн буй орчны талаарх уламжлалт ойлголтыг судалж уг уламжлалт ойлголт өнөөдөр ямар хэмжээнд байгаа болон хэрхэн өөрчлөгдөж байгаа, түүнд ямар хүчин зүйлүүд нөлөөлж буйг илрүүлэх зорилгоор 2000-2001 онд

Увс, Хэнтий аймаг, Дархан, Улаанбаатар хотуудаас нийгмийн янз бүрийн давхаргад хамрагдах 498 хүнээс / Увс- 130, Хэнтий-130, Дархан -50, Улаанбаатар -188 / нийгэм соёлын антропологийн шинжлэх ухаанд түгээмэл хэрэглэгддэг богино хугацаанд олон хүнийг хамрах боломжтой анкетийн арга болон хагас зохион байгуулагдсан ярилцлагын аргаар санамсаргүй түүвэр хийн судалгаа авч судалгааны материалаа цуглуулсан юм. Судалгаанд нийт 498 хүн хамрагдсанаас эрэгтэй - 250, эмэгтэй -248 хүн байлаа./ Хүснэгт-1/

Хүснэгт:1. Судалгаанд оролцогсдын хүйсийн байдал

№	Хүйс	Тоо	Хувь
1.	Эрэгтэй	250	50.2 %
2.	Эмэгтэй	248	49.8 %
3.	Дүн	498	100 %

Судалгаанд оролцогсдыг насны байдлаар авч үзвэл: / Хүснэгт -2 /

Хүснэгт 2. Судалгаанд оролцогсдын насны бүтэц

№	Насны бүлэг	Хувь
1.	18-25	32.8 %
2.	26-33	22.2 %
3.	24-41	16.7 %
4.	42-49	13.1 %
5.	50-57	10.1 %
6.	57- дээш	5 %
7.	Дүн	100 %

Судалгаанд Увс, Хэнтий аймгууд болон Дархан, Улаанбаатар хотуудад амьдарч байгаа халх, дөрвөд, хотон, баяд, мянгад, буриад, казах, урианхай зэрэг ястнууд хамрагдсан болно. Судалгаанд оролцогсдыг боловсролын байдлаар ангилж үзлээ. /Хүснэгт -3/

Хүснэгт: 3. Судалгаанд оролцогсдын боловсролын төвшин

№	Боловсрол	Хувь
1	Дээд	48.5%
2	Тусгай дунд	12.6 %
3	Бүрэн дунд	34.4 %
4.	Бүрэн бус дунд	4 %
5.	Бага	0.5 %
6.	Дүн	100 %

Судалгааны материал, тоо баримтад нийгэм соёлын антропологийн шинжлэх ухаанд өргөн хэрэглэгддэг орчин үеийн математик статистик арга болон социологийн судалгааны боловсруулалтын SPSS программыг ашиглан боловсруулалт хийлээ. Мөн экологийн болон хүрээлэн буй орчинтой холбоотой асуудлаар хэвлэгдэн гарсан

судалгаа шинжилгээний бүтээл, ном зохиолтой танилцан энэхүү бүтээлдээ ашигласан юм.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН, ХЭЛЦЭМЖ

Хүрээлэн буй орчны талаарх Монголчуудын уламжлалт ойлголт, түүний өөрчлөлт

Улаанбаатар, Дархан хот болон Увс, Хэнтий аймгуудаас цуглуулсан судалгааны материалуудад боловсруулалт хийж үзэхэд судалгаанд оролцогчдын 52,5 хувь нь хүнийг хүрээлж буй бүх зүйлийг хүрээлэн буй орчин хэмээн ойлгодог байсан хэмээн хариулжээ. Судалгаанд оролцогчдын 71,8 % нь байгалийн хүчин зүйлийг, 19,2 % нийгэм - соёлын хүчин зүйлийг хүрээлэн буй орчинд хамааруулан үздэг байсан байна.

Судалгаанд оролцогчдын насны байдлаас авч үзэхэд 18-35 хүртлэх насны залуучуудын хүрээлэн буй орчныг ойлгох ойлголтонд байгалийн хүчин зүйлүүдийн зэрэгцээ нийгмийн хүчин зүйлүүдийн эзлэх хувь давамгайлсан байна. Тухайлбал:

- Байгаль /81,5%/
- Ан амьтан /80%/
- Цаг агаар /77%/
- Уул, ус /71,5%/
- Мод, ургамал/70%/
- Нийгэм /60,9/
- Байгалийн үзэгдэл /50%/

Ахимаг хүмүүсийн 39.1 хувь нь нийгмийн хүчин зүйлсийг хамааруулан ойлгож байгаагаас үзэхэд тэдний хүрээлэн буй орчныг ойлгох уламжлалт ойлголтонд байгалийн хүчин зүйлс голлох байрыг эзэлдэг байсан нь тэдний хариултаас харагдаж байна. Судалгаанд оролцогчдын боловсролын төвшин дээшлэх тусам хүрээлэн буй орчныг нийгмийн /52,2%/ болон байгалийн /57,9%/ хүчин зүйл хэмээн ойлгодог байхад боловсролын төвшин доошлох тутам цаг агаар, уул, ус, мод, ургамал хэмээн ойлгодог хандлагатай байгаа нь ажиглагдлаа.

Энэхүү судалгааны үр дүнгээс харахад ан амьтан, ургамал, газар, ус, цаг агаар гэх мэт байгальтай холбоотой бүхий л зүйлийг цогцод нь авч үзэж / 71,8%/ хүрээлэн буй орчин хэмээн ойлгосоор ирсэн нь харагдаж байна. Харин залуучууд / 60,9%/ болон боловсролын төвшин өндөртэй хүмүүс / 60,9%/ нийгмийн хүчин зүйлийг хүрээлэн буй орчин гэсэн ойлголтонд оруулж үздэг байсан нь давамгайл байлаа.

Монголчуудын хүрээлэн буй орчны талаарх уламжлалт ойлголтыг бүтцээр нь авч үзвэл: **Байгаль** / Ургамал, Ан амьтан, Агаар мандал, Ус, Ой мод, Газар, Хөрс/ , **Нийгэм** гэсэн бүтэцтэй байлаа.

Судалгаанд оролцогчдын 62,6 % нь хүрээлэн буй орчны талаарх өмнөх ойлголт өөрчлөгдсөн, бидний хүрээлэн буй орчныг ойлгох ойлголт өөрчлөгдөхөд:

- ✓ Байгалийн тэнцвэрт байдал алдагдсан /26,8%/
- Бохирдолт ихэссэн /19,7%/
- Хүний байгальтай харилцах харьцаа өөрчлөгдсөн/ 19,2%/
- Эдийн засгийн өөрчлөлт / 19,2%/
- Нийгмийн өөрчлөлт /16,2%/
- Ухамсар /14,1%/
- Ган, зуд /13,6%/

- Хуулийн хяналт /4%/

• Хотжилт /2,5%/ зэрэг хүчин зүйлүүд нөлөөлсөн гэж хариулсан боловч хариултад анализ хийж үзэхэд хүрээлэн буй орчныг ойлгох уламжлалт ойлголт зарчмын хувьд хэвээрээ байгаа нь харагдаж байна. Харин бүтцийн хувьд нилээд өргөн хүрээг хамрах болсон байна. Тухайлбал: Гэр бүл, хүн, соёл гэсэн хүчин зүйлүүдийг хүрээлэн буй орчин гэсэн ойлголтонд хамааруулж үзжээ. Энэ нь нийгэм эдийн засгийн шинэ тогтолцоонд шилжин орсон үйл явцтай холбоотойгоор монголчуудын соёл, ертөнцийг үзэх үзэл өөрчлөгдөж байгаатай холбоотой байна. Судалгаанд оролцогчдын хүрээлэн буй орчны талаарх одоогийн ойлголтыг авч үзвэл: / Хүснэгт-1/

Хүснэгт 1. ХБО талаарх одоогийн ойлголт

Д/д	Хүрээлэн буй орчны талаарх ойлголтын бүтэц	Хувь
1,	Уул, ус	43,9%
2,	Байгаль	40,4%
3,	Мод ургамал	36,4%
4,	Цаг агаар	34,8%
5,	Ан амьтан	30,8%
6,	Газар	24,7%
7,	Нийгэм	23,4%
8,	Гэр бүл	9,6%
9,	Хүн	7,1%
10,	Соёл	5,1%
11,	Бүх юм	54%

Судалгаанд оролцогчдын хүрээлэн буй орчны талаарх одоогийн ойлголтыг насны бүтцээр нь авч үзэхэд залуучуудын хүрээлэн буй орчны талаарх ойлголтонд гэр бүл, хүн, соёл гэсэн хүчин зүйлүүдийн эзлэх хувийн жин / гэр бүл /72,7%/, хүн /71,4%/, соёл /80%/ их байна. Эндээс харахад залуучуудын хүрээлэн буй орчныг ойлгох ойлголтын бүтэц нь ахмад үеийнхнийг бодвол илүү өөрчлөгдсөн байна. Ахмад настнуудын хувьд хүрээлэн буй орчныг ойлгох уламжлалт ойлголт өнөөдөр бараг хэвээр хадгалагдан үлдсэн байна. Судалгаанд оролцогчдын хариултаас үзэхэд шинээр гарч ирсэн хүчин зүйлүүдийн эзлэх хувийн жин боловсролын төвшин өндөртэй /дээд боловсролтой/ хүмүүсийн хариултанд их байгаа нь / Гэр бүл 70 %/, соёл /63,2%/, хүн /42,8%/ харагдаж байна.

МОНГОЛЧУУДЫН ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИНД ХАНДАХ ХАНДЛАГА

Судалгаанаас гарсан үр дүн болон, монголчуудын хүрээлэн буй орчныг ойлгох ойлголтонд тулгуурлан хүрээлэн буй орчинд хандах хандлагыг бүтцээр нь дараах байдлаар авч үзэж байна.

1. Ан амьтанд хандах хандлага: Монголчууд эрт үеэс эхлэн ан амьтантай харьцах, ан агнах нарийн журмыг баримтлан мөрдөж ирсэн. Тухайлбал: Ан агнахаар товлосон өдрөө хэлдэггүй, адууны хомоол өгч гаригийн нэрээр нэрлэх, хугацаагаа далдуур тохирдог ёсон байдаг. Ан агнахаар явж буй анчиддаа “ Ганзагандаа антай,

гартаа тостой ирээрэй”, “ Ан элбэг, олз их “ гэх мэтийн бэлэг дэмбэрэлийн үгс хэлдэг байна. Түүнчлэн Урианхай ястан анд явахын урд орой туульч авчран “ Алтайн магтаал” хайлуулдаг байсан нь уул усны магтаал хэлж , ан амьтдыг нь магтвал түүний эзэн лус савдгууд баярлан ангийн хишиг өгдөг гэж үздэг байсантай холбоотой. Мөн Өөлдүүд эрт үед анчдыг анд явахад нь үдэж гаргахдаа дуу дуулдаг ч зан үйл байсан. Анчид ан амьтны хүч тарга, үс, арьс гүйцсэн хугацааг тохируулан намар, өвлийн улиралд хорио тавигдсан цагт агнаж байсан уламжлалтай. Ан амьтныг сүргээр нь устгах, хээлтэй үед нь болон үр төлөө дагуулсан амьтдыг агнахыг хориглодог байсан . Тэр ч бүү хэл хос амьтдыг ч агнахыг цээрлэдэг байсан уламжлалтай. Мөн анд явж байх үедээ хоорондоо маргалдах, ан амьтдын тухай бүдүүлэг үг хэлэлцэхийг цээрлэх, амьтдын нэрийг цээрлэж далд утгатай үгээр цээрлэн нэрлэдэг. Ан гөрөөсний хөгшин , доголон зэргийг эхлэн агнадаг . Харин өөрийгөө хамгаалж чадахгүй болсон амьтныг агнахыг хориглодог. Ан хийсний дараа хангай дэлхийдээ мөргөн адис авч аргагүйн эрхээр амьтныг хөнөөсөндөө хүлцэл өчин залбирал үйлддэг байсан төдийгүй ан амьтны нэрээр газар нутгийг нэрлэж байв. Тэр ч бүү хэл усны шувуудыг бэлгэшээн угтаж ерөөлийн үгс хэлдэг байсны зэрэгцээ буцаж байгаа шувуудыг харах, тоолохыг цээрлэдэг байв. Дээрх ойлголт нь одоо хүртэл уламжлагдан ирсэн бөгөөд хөгшчүүл үр хойчдоо зааж сургасаар байна. Монголчууд эртнээс ан амьтныг шүтэж байсныг хадны сүг зураг, буган хөшөө, булшнаас гарсан хэрэглэгдэхүүнүүдээс харахад тодорхой байдаг. Хадны сүг зураг, буган хөшөө , домог үлгэр зэргээс харахад монголчууд эртнээс бугыг эрхэмлэн шүтдэг байсан нь тодорхой харагддаг. Тухайлбал: Хараагийн Ноён уулын булшнаас мал ,ан амьтан (сарлаг, буга) зэргийг зээгт наамлаар хооронд нь тэмцэлдэж байгаагаар дүрсэлсэн эсгий ширдэг олджээ. Р.Нарантуяагийн бичсэн “Буга эрхэмлэх зан үйлийн ул мөр аман зохиолд уламжлагдсан нь” гэсэн өгүүлэлд: /...Агнасан бугыг өвчихөөсөө өмнө толгойг нь салган модонд өлгөж, газарт цагаан даавуу дэвсэн түүн дээрээ эврийг нь шороодолгүйгээр авч буга агнасан айлын гэр дээр тавьдаг. Дараа нь анд явалцсан хүмүүс хамт цайлсны дараа бугынхаа эврийг баруун хананд өлгөдөг уламжлалтай байсан / гэжээ.

Мөн дархад ястнууд буга агнаад эврийг нь гэмтээлгүй авч , хангайдаа 3 мөргөөд ерөөлийн үгс хэлж эврийг нь гартаа барьж морио унан гэртээ буцдаг. Гэрийн эзэгтэй нь морины уян дээр эврийг хормой дээрээ тосон аваад гарийнхээ баруун талаар өгсөж хоймртоо залдаг байна. (С.Бадамхатан 1965)

Эдгээрээс үзэхэд монгол ястнуудын бугыг шүтэх ёс агуулгаараа бараг ижил байна. Гэтэл өнөөдөр энэ буга шүтэх ёс бараг мартагдсан байна. Судалгаанд оролцогсдын 11.6 % нь зах зээлийн систем хүмүүсийн байгаль орчны талаарх уламжлалт ойлголт өөрчлөгдөхөд нөлөөлсөн гэж хариулсан байна. Үнэхээр ч өнөөдөр хүмүүс бугын эвэр, чив сүүлийг худалдаж ашиг хонжоо олохын төлөө бугыг олноор нь агнан энэхүү ёс заншлыг умартаж байна.

Плано Карпини, Банзарын Дорж зэрэг эрдэмтдийн тэмдэглэлд ан амьтныг олноор агнахгүй шувууны үр төлийг хөндөхгүй зэрэг хуультай байсан хэмээн тэмдэглэгдсэн нь монголчууд ан амьтныг шүтэх эртний уламжлалтай байсныг харуулж байна. Зарим судлаачдын тэмдэглэснээс үзвэл баавгайг ойн эзэн гэж үзэн зөвхөн амьжиргааны эрхээр агнадаг байжээ. Баавгайг алсан анчин толгойг нь гэрийнхээ тооно, багананд уяж тахин шүтдэг байсан байна. Мөн шонхор шувууг Чингисийн үеэс шүтэж иржээ. Гэтэл өнөөдөр шонхор шувуугаар Араб руу бизнес хийж байгаа нь тэр сайхан уламжлал үгүй болсоныг харуулж байна. Монгол хүн загасыг хайрлан хамгаалж бэлэгдэлийн ёсонд хүндэлж байжээ. (Х. Нямбуу 1992) Гэтэл мөн л өнөөдөр энэ уламжлал үгүй болж хууль дүрмийг зөрчин загасыг сүйтгэж байна. Дээр бичсэн зүйлүүдийг нэгтгэж дүгнэхэд

Монголчуудын ан амьтныг ойлгох, шүтэн бишрэх, тахих уламжлал нь тэдгээр ан амьтныг өсөн үржих бололцоог хангаж өгч байсан байна.

2. Цаг агаарт хандах хандлага: Монголчууд ан амьтад, малын үйл хөдлөлийг байнга ажиглаж мэдсэний үндсэн дээр цаг уурын өөрчлөлтийн тухай маш их туршлага хуримтлуулсан байдаг. Тухайлбал: Амьтан эрт ичвэл, буга орой дуудвал зуд болох, аргал угалз, бор гөрөөс талд буувал ган болох, хөхөө эрт донгодвол зун богино болж эрт намарших, усны шувууд доогуур нисвэл хур ихтэй, мал шөнө хөлөө жийж хэвтвэл шуурга болох, мэлхий зэрэг лусын амьтныг алвал тэнгэр задрах, хар хэрээ дуугарвал цас их орох гэх мэтээр цаг агаарын байдлыг урьдчилан мэддэг байв. Жишээ нь: Уулын бор гөрөөс намрын эхний цасны үеэр модны зах хамар хяраар хэвтвэл өвөл нь өнтэй, говьд могой нүхнээс ил гарах нь бороо орох, тарвага нүхнийхээ амсарыг тойруулан чулуу шороогоор хүрээлбэл үер болох, тарвага хавар эрт ичээгээ цоолбол дулаан болох, хараацай өндөрт нисэж байвал бороо орно, дэвхрэг голио элбэгшвэл ган болно, ятуу уул бараадахаар хүйтэрдэг гэх мэт ойлголт төсөөлөлтэй байсан. (Ш.Төмөрбаатар 1984)

Мөн монголчууд ургамлын гарцыг ажиглан цаг агаарын байдлыг урьдчилан мэддэг уламжлалтай байжээ. Тухайлбал: Ногоо ишээ гүйцэд ургаагүй байхад цэцэглэвэл гандуу байх, уулын мод оройгоосоо шарлавал зудархуу, шар цэцэг их ургавал цас орно, багваахай цэцэг их ургавал бороо ховортой зуншлага тааруу болдог гэх мэтээр өвс ургамлыг ажиглан мэдсэний үндсэн дээр цаг агаарын байдлыг урьдчилан мэддэг байв.

3. Устай холбоотой уламжлалт ойлголт: Ус бол экологийн нэг чухал бүрэлдэхүүн бөгөөд усыг хэрхэн манай монголчууд амьдрал ахуйдаа хэрэглэдэг байсан тухай авч үзье. Усыг ариун тунгалгаар нь байлгах, усанд сүү, цагаан идээ оруулбал усны амьтдад муу, ус булгийн эхэнд хог новш хаях, хир буртгаа угаахыг хатуу цээрлэж байжээ. Усны ойр нас барсан хүн тавьдаггүй, усны эхийг хөнддөггүй зэргээр сургадаг байсан. Чингисийн "Их засаг" хуулинд ус авахдаа хутгуур хэрэглэж байх ёстой, усыг гараараа уух, усанд гараа дүрэхийг хориглох тухай заасан байдаг бөгөөд ус буртаглавал малаар торгодог байжээ.

Монгол түмэн үе улиран хайрлаж шүтэж, өвгөд дээдсийн өвлүүлэн үлдээсэн рашаан усны тухай түүх шастирт тэмдэглэгдсэн байдаг. Тухайлбал: "Чингис хаан рашаан ус хэрэглэж байжээ." (С. Дэмбэрэл 1997) Манай ард түмэн өвчин эмгэгийг эдгээж, эрүүл болгодог байгалийн усыг рашаан хэмээн Аршийн орны увидаст угаал гэж өргөмжилдөг. Мөн эртнээс шүүдрийн усыг анагаах сэтгэлийг сэргээх, шингэн тунгалаг, амтгүй, сэрүүн, хөнгөн зэрэг найман зүйлийн эрдэм бүрэлдсэн хэмээн нас уртасгана гэж ихэд эрхэмлэдэг. Монголчууд рашаан, булаг усыг тахиж, өргөл тахил өргөдөг. Рашаан булагт ихэвчлэн хадаг, дал зэргийг зүүж, түүний эхэнд юм угаах, хог хаях, сүү цагаан идээ дусаах зэргийг цээрлэнэ. Мал, хүн өвдөх тохиолдолд рашаан усанд элдэв юм оруулснаас газар ус догширлоо гэж ойлгодог.

4. Мод, ургамалд хандах хандлага: Монголчууд өвс ургамлыг хайрлан хамгаалж, хөндөн хугалахыг цээрлэн хүндэтгэн билэгдэж ирсэн уламжлалтай. Монголчуудын дунд янз бүрийн мод ургамлыг ид шидтэйд тооцож хүн малд тохиолдох саад тотгорыг зайлуулах, өвчин эмгэгээс хамгаалах зорилгоор онго хэлбэрээр зүүж хэрэглэх ёс байв. (С. Дэмбэрэл 1997) Монголчууд зуны дэлгэр цагт мод огтлох, залуу мод авах, булаг шандны эхнээс мод огтлохыг цээрлэдэг байсан нь байгалийг төлжиж байгаа үед саад хийхгүй гэсэн санаатай. Мөн түүнчлэн хэсэгхэн төгөл, зулзган модыг огтолдоггүй, сондгой ургасан өнчин ганц мод, хуурайшиж өгөршсөн мод, эртнээс тахилгатай явсан уул ус бүхий газрын модонд гар хүрч хөндөх, ургамлыг иш үндсээр нь авч хугалж гэмтээхийг хатуу хориглодог. Мөн

модонд мэс хутгахүргэдэггүй, яргай зэрэг догшин модыг тайрдаггүй лус савдаг догширно гэж ойлгон шүтэж иржээ. Яргай мод тайрахаар бол хэлгүй хүнийг авчирч тайруулдаг. Энэ нь хэлгүй хүнд лус савдаг халдахгүй гэж үздэг. Шүтэж эрхэмлэх мод, ургамал нутгийн онцлог байдлаас шалтгаалан ялгаатай байдаг бөгөөд говийн бүс нутгийн хүмүүс заг, сухай, яргай, арц, хайлаас зэрэг модыг хүндлэн шүтдэг байхад хангай бүс нутгийнхан бургас, хус тэргүүтнийг дээдэлдэг байна.

Мөн өвс ургамлаар сав суулга, араг хийж амьдрал ахуйдаа хэрэглэдэг уламжлалтай. 1640 оны "Монгол – Ойрадын Их цааз"-д өвс ургамал ой модоо хамгаалах тухай тодорхой заасан байдаг. 14-р зууны үед байгаль дэлхийн өвс ургамлуудын дотроос эмийн ургамлыг онцлон анхаарч байсан тухай баримтууд байх бөгөөд эмийн ургамалтай газрыг малын хөлөөс, гал түймрээс хамгаалж хүн ардын өвчинд өргөн хэрэглэж байсан нь байгалийн ургамалтай харьцах асуудал эртнээс уламжлалтай болох нь харагдаж байна.

5. Газар дэлхийд хандах хандлага: Нүүдэлчин Монголчууд Ази, Европын бусад зарим улс түмний адил хөх тэнгэрийг эцэгтэйгээ, хөрст дэлхийг эхтэйгээ зүйрлэн хүндэтгэж, шүтэн биширч уул усандаа цай сүүнийхээ дээжийг өргөдөг нь уул хангай маань цаана эзэнтэй хэмээн (богд хаан) хүндэтгэдэг сүсэг бишрэлтэй холбоотой юмаа. Газар дэлхийг мэдрэл судалтай адилтгаж газрыг эвдвэл байгаль үхдэг гэж үзэж байсан нь улс орон, түмэн олноо амар амгалан байж хөгжөөсэй гэсэн агуулгатай болох нь харагдаж байна. Шинэ нутагт буухдаа гоёлын хувцсаа өмсөх, үдэш орой муу юм зайлуулахаар буу буудах, оршуулах газар авахдаа ёслол үйлдэж лус савдаг догшрохоос сэргийлэх, нутагладаг газрынхаа ойролцоо нас барсан хүн тавьдаггүй, нүүдэл хийхдээ бууцаа цэвэрлэх, гадас шонгоо сугалж авдаг, газар шороон дээр зурж сэндийчихийг нүгэл гэдэг, малчин ардууд үнс нурам, хогоо ил задгай орхидоггүй газар булж орхидог зэргээс үзэхэд монголчууд байгаль орчноо газар дэлхийгээ хэрхэн ойлгож шүтэн биширч байсан нь тодорхой байна. Газар дэлхийтэй холбоотой уламжлалаас нийтийг хамарсан шинжтэй нь уул овоо тахих зан үйл юм. 1911 онд Богд хааны зарлигаар Хан ууланд <хайрхан> цол өргөмжилж Богд хан хайрхан, Чингэлтэй 2 ууланд хамаагүй зугаалах, жимс самар түүхийг хоригложээ. Уул овоогоо онголон тахиж тэр орчныхоо мод ургамал, ой модыг огтлох, түүх хориотой байсан бөгөөд овоо босгож цай сүүнийхээ дээжийг өргөн, уншлага уншин, овоонд мод чулуу нэмэрлэн бөх барилдуулах, морь уралдуулах зэрэг жижиг наадам хийдэг байсан. Овоо тахих ёслолд эмэгтэй хүн очдоггүй ёстой. Овооны дэргэдүүр өнгөрөх хүн мориноосоо бууж овоог 3 тойрон, хадаг уяж, мод чулуу өргөн хүндэтгэл үзүүлдэг байжээ.

1921 он хүртэлх хугацаанд уул ус тахиж тэр орчны мод бут ургамалыг түүх, ан амьтадыг агнах нь цээртэй байсан нь байгаль орчноо хамгаалах нэг хэлбэр болж байсан бөгөөд тухайн үед шүтлэг бишрэлтэй холбогдуулан байгаль эрхсээ хамгаалахад чиглэгдсэн арга хэмжээ байжээ. Эндээс үзэхэд монголчуудын хүрээлэн буй орчинд хандах уламжлалт хандлага нь шашны сургаалийн болон зан үйлийн хэв шинжийг агуулсан байна. Гэхдээ үндсэн агуулга нь байгалийг бишрэн сүсэглэх үр шимийг нь хүсч мөргөл залбирал үйлдэх зэргээр илэрч байгаа бөгөөд байгалийг танин мэдэх, байгалийн тэнцвэрийг алдагдуулахгүй нөөц баялагийг амьдрал, ахуйдаа хэрэглэх, хүрээлэн буй орчиндоо хайр гамтай хандахад чиглэгдэж байжээ.

Судалгаанд оролцогчдын 79,3% нь хүрээлэн буй орчинд хандах монголчуудын хандлага өөрчлөгдсөн гэж хариулсан бөгөөд тэдний 54,9 % нь ашиглах болсон, 40% сүйтгэх болсон, 5,1 % нь хамгаалах болсон гэж хариулжээ. 1990-ээд оноос өмнө байгаль хамгаалах арга хэмжээ их авч /32,8%/, зан үйлээр /23,7%/, хууль эрхийн актаар /21,7%ны/, зан заншлын уламжлалаар / 18,7%/ байгаль орчноо хамгаалдаг байсан тогтолцоо алдагдсанаар байгаль орчинтой зүй бусаар харьцах, сүйтгэх гэх

мэтийн олон сөрөг үр дагаварыг авчирч байна гэж үзсэн. Үнэхээр ч зах зээлийн эдийн засгийн системд шилжиснээр ажилгүйдэл, ядуурал газар авч монголчуудын амьдралын төвшин доройтох болсноор хүмүүс байгаль орчны нөөц баялагийг ашиглан амьжиргаагаа дээшлүүлж болно гэсэн ойлголттой болжээ.

Энэхүү судалгааны дүн болон уламжлалт хандлагаас үзэхэд хүрээлэн буй орчинд хандах монголчуудын хандлага ихээхэн өөрчлөгдсөн болох нь харагдаж байна.

Хүрээлэн буй орчноо хамгаалахын тулд юу хийх вэ гэсэн асуултанд судалгаанд оролцогчдын 42,4% нь хуулийг чангатгах, 35,9% нь байгаль хамгаалах арга хэмжээ зохиох, 35,7% нь байгаль хамгаалах ухамсар төлөвшүүлэх, 33,3% нь байгалийг нөхөн сэргээх, 15,7% нь суртачилгаа хийх, 13,1% нь төрөөс байгаль орчныг хамгаалах бодлого явуулах, 7,1% нь хог цэвэрлэх, 4,5% нь ядуурлыг бууруулах хэрэгтэй гэж хариулсан байгаагаас үзэхэд байгаль орчин эзэнгүйдэж байгааг харуулж байна. Нөгөө талаар байгаль хамгаалах төрийн бодлого үгүйлэгдэж байгаа нь нэгэнт бодит зүйл болжээ.

ДҮГНЭЛТ

Судалгааны үр дүнд тулгуурлан дараах дүгнэлтийг хийж байна.

Монголчуудын хүрээлэн буй орчны талаарх уламжлалт ойлголтод ан амьтан, мод ургамал, газар, ус, цаг агаар гэх мэт байгальтай холбоотой бүхий л зүйлийг цогцод нь авч үзэх хандлага уламжлагдан ирсэн бөгөөд өнөөдөр ч энэхүү уламжлалт ойлголт зарчмын хувьд бараг өөрчлөгдөөгүй хэвээр байна. Харин залуучууд болон боловсролын төвшин өндөртэй хүмүүс энэхүү ойлголтод нийгмийн болон соёлын хүчин зүйлийг хамруулж ойлгох болсноор бүтцийн өөрчлөлт гарчээ. Энэ нь нийгэм эдийн засгийн шинэ тогтолцоонд шилжин орсон үйл явцтай холбоотойгоор монголчуудын соёл, ертөнцийг үзэх үзэл өөрчлөгдөж байгаатай холбоотой байна.

Монголчуудын байгаль дэлхийгээ шүтэн бишрэх, хайр ивээлийг нь хүсэх, хайрлан хамгаалах хандлага нь тэдний эрхлэх аж ахуй, амьдралын хэв маягтай салшгүй холбоотой. Энэхүү хандлага нь зан заншлын төдийгүй хууль эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдсаар ирсэн нь монгол орны хүрээлэн буй байгаль орчин бага хөндөгдсөн, унаган төрхөөрөө хадгалагдан өнөөг хүрэхэд чухал нөлөө үзүүлсэн. Гэвч 1990-ээд оноос хойш гарсан нийгэм-эдийн засаг, соёлын өөрчлөлт нь монголчуудын байгаль орчинд хандах уламжлалт хайрлан хамгаалах хандлага өөрчлөгдөхөд нөлөөлжээ. Өнөөдөр байгалийн нөөц боломжыг ашиглан амьжиргаагаа дээшлүүлж болно гэсэн ойлголт хүмүүсийн дунд газар авснаар байгаль орчны тэнцвэрт байдлыг олон үеийн турш хадгалан ирсэн зохистой хэрэглээг үл огоорон хэн дуртай нь дураараа авирлах болсон нь түгшүүрийн харанга дэлдэж байна.

Ном зүй

1. Амархүү О. "Байгаль орчныг хамгаалах Монгол зан заншил, хууль цааз: уламжлал шинэчлэлийн асуудал" УБ 2000 он
2. Амархүү О. "Хүрээлэн буй орчныг хамгаалах төр эрхийн онолын зарим асуудал" УБ 1979 он
3. Базаргүр Д. "Бэлчээрийн Мал аж ахуйн газарзүйн ухаан" УБ 1996 он
4. БНМАУ-ын Угсаатны зүй 1-р боть УБ 1987 он
5. Гонгоржав Г. "Монголчуудын эрдэм ухааны уламжлал" УБ 1995 он

6. Дашзэвэг Б. "Байгалиа хамгаалж ирсэн Монголчуудын хууль цаазын эртний уламжлал" УБ 1995 он
7. Дэмбэрэл С. "Баян хангай" 4-р дэвтэр УБ 1997 он
8. Дэмбэрэл С. "Газар эх" 1-р дэвтэр УБ 1997 он
9. Дэмбэрэл С. "Сүн далай" 3-р дэвтэр УБ 1997 он
10. Дэмбэрэл С. "Сүмбэр уулаа хамгаалах нь" УБ 1997 он
11. Жуковская И.Л. "Категорий и символика традиционной культуры монголов" М. Наука 1988 г
12. Пэрлээ Х. "Монголчууд байгаль хамгаалах заншилтай" УБ 1974 он ШУА № 2 12-14-р тал
13. Төмөржав М. "Малчны сэтгэлзүй ёс суртахууны уламжлал" ХАА сэтгүүл №6 УБ 1992 он
14. Төмөржав М., Н. Эрдэнэцогт "Монголын нүүдэлчин" УБ 2000 он
15. Төмөрбаатар Ш. "Монгол түмний тэнгэр унших эрдэм" УБ 1984 он
16. Төрбилэг Ц. "Байгаль орчноо хайрлах монгол хүний сэтгэлзүй" УБ 1986 он
17. Шаралдай Н. "Нүүдлийн соёл хийгээд эх шүтлэг" Ил товчоо №16, УБ 1997 он
18. Шагдарсүрэн О. "Экологийн танин мэдэхүйн үндэс" УБ 1999 он